

## Банкны салбарын эргэн тойронд

04.07 – ХХБ Оюу толгой ХХК-ийн ханган нийлүүлэгчдэд зориулж авлага барьцаалсан зээл олгож эхэллээ. [tdbm.mn](http://tdbm.mn)

04.07 – Төрийн банк “Монгол Шуудан” ХК-тай хамтран харилцагчдынхаа захиалсан төлбөрийн картыг баталгаат шуудангаар хүргэж өгөх үйлчилгээг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. [statebank.mn](http://statebank.mn)

04.10 – Банк хоорондын валют арилжааны цахим талбарын үйл ажиллагаа эхэллээ. Ингэснээр банк хоорондын валютын зах дахь төлбөр тооцоо, мэдээллийн эрсдэлийг бууруулах бөгөөд спот ханш



### СПОТ ХЭЛЦЭЛ

СПОТ ХЭЛЦЭЛ ГЭДЭГ НЬ ВАЛЮТ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ЯАРАЛТАЙ БУЮУ ИХЭНДЭЭ НЭГ ХОНОЙН ХУГАЦААНД ВАЛЮТЫГ БЭЛЭН ЗАРАХ БА ТҮҮНИЙ ТӨЛБӨРИЙГ ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭ ЮМ.

бүрэлдэх, валютын захын хүртээмж, ил тод, нээлттэй байдал нэмэгдэх, мэдээллийг Монголбанк цаг алдалгүй түргэн шуурхай авч, шаардлагатай үед зах зээлд оролцох, валют арилжааны нэгдсэн талбар бий болгох үндэс суурийг тавих зэрэг ач холбогдолтой. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

04.10 – ХААН Банк Монголд анх удаа бүсгүйчүүдэд зориулсан “Glamour” кредит картыг шинээр нэвтрүүллээ. [khanbank.com](http://khanbank.com)

04.20 – Төрийн банк болон БНХАУ-ын Бүтээн Байгуулалтын банкны хамтын ажиллагаа шинэ шатанд гаргаж “Хамтран ажиллах санамж бичиг”-т гарын үсэг зурлаа. [statebank.mn](http://statebank.mn)

05.11 – Уур Амьсгалын Ногоон Сангаас ХасБанканд 20 сая долларын санхүүжилтийн эхний багцыг шилжүүллээ. [xacbank.mn](http://xacbank.mn)

05.12 – Хаан банк жижиг дунд бизнес (ЖДБ) эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүхий л үйлчилгээг нэгтгэсэн “ХААН Бизнес” үйлчилгээг шинээр гаргаж, харилцагчиддаа хүргэлээ. [khanbank.com](http://khanbank.com)

05.15 – Ариг Банкны хамт олон НҮБ-ын Хүн Амын сангийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахаар Хамтын ажиллагааны санамж бичиг гарын үсэг зурлаа. [arigbank.mn](http://arigbank.mn)

05.18 – ХААН Банк Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас хамтран хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөл бүхий цалингийн зээлийг салбар нэгжээрээ дамжуулан олгож эхэллээ. [khanbank.com](http://khanbank.com)


05.31 – Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэхээр тусгай хяналтын алба байгуулав. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

06.09 – Хилийн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпораци (OPIC – The Overseas Private Investment Corporation) болон Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC – International Finance Corporation), ХасБанк нар Монгол Улсын жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа. [xacbank.mn](http://xacbank.mn)

06.09 – УБХБанк нь Замын хөдөлгөөний удирдлагын төвтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. [ubcbank.mn](http://ubcbank.mn)

06.13 – УБХБанк аж ахуй нэгжүүдэд зориулан алт барьцаалсан зээлийн үйлчилгээг шинээр үзүүлж эхэллээ. [www.ubcbank.mn](http://www.ubcbank.mn)

## Банкны салбарын гол үзүүлэлтүүд /татан буугдсан банкуудыг хассанаар/




**Нийт актив = 25,8 их наяд төгрөг**

Банкны салбарын нийт актив 2017 оны 2-р улиралд 25,8 их наяд төгрөг болж өмнөх улирлаас даруй 0,6 их наяд төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 2,5 их наяд төгрөгөөр өслөө.




**Чанаргүй зээл 7,4%-д хүрлээ**

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 7,4%, нийт дүнгээр авч үзвэл 930 тэрбум төгрөг байна. Чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 2 улирал дараалан буурсан хэдий ч энэ улирал өслөө.



**Ипотекийн зээл = 4,2 их наяд төгрөг**

Нийт ипотекийн зээл 4,2 их наяд төгрөг хүрсэн бол үүнээс орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (ОСИСТТБ)-н дагуу 3,2 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Ипотекийн зээлийн хэмжээ тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш тогтмол өссөөр байна.



**Харилцах+Хадгаламж=12,8 их наяд ₮**

Нийт банкны салбарын харилцах ба хадгаламжийн нийлбэр өмнөх оны мөн үеэс 22% буюу 2,3 их наяд төгрөгөөр өссөн бол өмнөх улирлаас 1,14 их наяд төгрөгөөр өсжээ.


# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2017 он – II улирал




Валют(Харилцах + Хадгаламж) = 3,6 их наяд ₮

Валютын харилцах өмнөх оны мөн үетэй харьцуулахад ердөө 1%-иар буюу 14 тэрбум төгрөгөөр өссөн бол валютын хадгаламж 2%-иар буюу 45 тэрбум төгрөгөөр өсжээ.



1\$=2367₮ 1¥=347₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2017 оны 6-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2367₮, Юань-ийн ханш 347₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.доллар 402₮-р, Юань 49₮-р өссөн үзүүлэлт юм. Валютын ханш 1 сараас хойш буурсаар байна.




Ашиг = 124 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2017 оны 2-р улирлын байдлаар 3,23 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17,6% өслөө. Харин банкны салбарын ашиг оны 2-р улирлын байдлаар 124 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн ашгаас 95 тэрбум төгрөгөөр илүү байна.



Банкны нөөц = 2.5 их наяд төгрөг


Банкны нөөц 2016 оны 11 сараас тогтмол буурсан хэдий ч энэ улирал өсөлттэй гарч 2,5 их наяд төгрөг хүрлээ.



Онцлох: Аймгуудын зээл ба хадгаламж<sup>1</sup>

Банкуудын 21 аймагт олгосон зээлийн үлдэгдэл 2016 оны эцсийн байдлаар 2,7 их наяд төгрөг байна. Үүнээс 2,7% нь чанаргүй буюу 73,7 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Харин нийт хадгаламжийн хэмжээ 1,46 их наяд төгрөг бөгөөд иргэдийн хадгаламжийн 76,8% нь хугацаатай хадгаламж байна.

Орхон аймаг хамгийн их буюу 221 тэрбум төгрөгийн зээлтэй байгаа бол Говь-Сүмбэр аймаг хамгийн бага зээлтэй. Чанаргүй зээлийн хувиараа Өмнөговь аймаг 5,6 хувьтайгаар тэргүүлж байгаа бол Архангай аймгийн хувьд ердөө 0,59% байна.



Орхон аймгийн иргэд хамгийн өндөр буюу 180 тэрбум төгрөгийн хадгаламжтай байгаа бол Говь-Сүмбэр аймгийн иргэд хамгийн бага буюу 10,9 тэрбум төгрөгийн хадгаламжтай байна. 21 аймгийн нийт хадгаламжийн хэмжээ 2015 оны эцсийн байдалтай харьцуулахад даруй 27,9%-иар өсжээ. Энэ нь орон нутгийн иргэд хуримтлал хийх нь эрс ихсэж буйг харуулж байна.



<sup>1</sup> Монголбанкнаас банкуудын зээл, хадгаламжийн үлдэгдлийг сумдаар гаргасан статистикийг ашиглав.

## Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2017 оны 2-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал болон Тээвэр хөгжлийн банкны мэдээлэл ороогүй болно.



### АКТИВ

### БАНКУУД

#### ТОМ-3 БАНК

>3 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк  
Хаан банк  
Голомт банк

#### ДУНД-3 БАНК

1-3 их наяд төгрөг

Хасбанк  
Төрийн банк  
Улаанбаатар хотын банк

#### БУСАД БАНКУУД

<1 их наяд төгрөг


Капитал банк  
Чингис хаан банк  
Капитрон банк  
Үндэсний хөрөнгө оруулалтын банк  
Ариг банк  
Богд банк  
Кредит банк  
Тээвэр хөгжлийн банк

## АКТИВ


Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт актив 24,6 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 72%, Дунд-3 банк 24%, жижиг банкууд 4 хувийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад Том-3 банкны актив 14%, Дунд-3 банкны актив 11%, жижиг банкуудын актив 7% тус бүр өсчээ. Хаан банк 6,77 их наяд төгрөгийн активтай хамгийн өндөр нь байгаа бол Кредит банк хамгийн бага буюу 17 тэрбум төгрөгийн активтай байна.


Зах зээлд эзлэх хувь, активаар, 2У'17



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь



Жижиг банкууд




## ЗЭЭЛ




Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт зээл 11,9 их наяд төгрөг байна. Үүнээс 70%-г Том-3 банк, 26%-г Дунд-3 банк, 4%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 6%-иар, Дунд-3 банк 11%-иар, жижиг банкууд 0,3%-иар тус тус зээлийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ 7% өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 2У'17



## Зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь






## ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ



Тайлант хугацаанд тайланд орсон нийт 12 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 13,7 их наяд төгрөг байна. Үүнээс 69,5%-г Том-3 банк, 24,5%-г Дунд-3 банк, 6%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 23%-иар, Дунд-3 банк 11%-иар, жижиг банкууд 88%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл 22,3%-иар өсчээ.


Зах зээлд эзлэх хувь, 2У'17



## Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



## Жижиг банкууд, тэрбум төгрөгөөр






## АШИГ

2017 оны 2-р улирлын байдлаар тайланд орсон 12 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 133 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах дүн) ажиллажээ. Тайланд орсон 12 банкны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53 тэрбум төгрөгөөр илүү ашигтай ажиллаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 54%-иар, Дунд-3 банк 141%-иар тус бүр ашгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн бол жижиг банкууд ашиггүй ажиллажээ

Банкуудын ашиг, алдагдал:



Эх үүсвэр:

1. Статистикийн бюллетень 2У'17, Монголбанк
2. Ипотекийн зээлийн тайлан 2У'17, Монголбанк
3. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 2У'17, Монголбанк
4. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
5. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 2У'17